



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 149. | Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай | Дугаар 30 | 589 |
| 150. | Зарим хүмүүсийг шүүгч,
Ерөнхий шүүгчийн албан
тушаалд томилох тухай | Дугаар 31 | 590 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 151. | Налайхын нүүрсний ордод хувиараа
нүүрс олборлож байгаа иргэдийн
аюулгүй ажиллагааг хангах талаар
авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 43 | 590 |
| 152. | Тооны дээд хязгаар, мөнгөн
төлбөрийн хэмжээ тогтоох тухай | Дугаар 47 | 591 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 02 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хараавчийн Аюурзаныг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Казахстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагирын Сүхээг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 03 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4, 32.6, 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Банзайн Манлайбаатарыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Загдаагийн Болдбаатарыг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Эрдэнэбилэгийн Оюун-Эрдэнийг Өмнөговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Чадраабалын Батчимэг, Галбадрахын Солонго нарыг Өмнөговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Мянгаагийн Баясгаланг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн, Сэлэнгийн Батгэрэлийг Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Доржийн Нямыг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Дамдинсүрэнгийн Оюунбатыг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус улируулан томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 2 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар
хот

Налайхын нүүрсний ордод хувиараа нүүрс олборлож байгаа иргэдийн аюулгүй ажиллагааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай

Налайхын нүүрсний ордод хувиараа нүүрс олборлож байгаа иргэдийн эрүүл мэнд, амь нас хохирох явдлыг таслан зогсоох зорилгоор Газрын хэвлийн тухай хуулийн 6.2, Ашигт малтмалын тухай хуулийн 3.2, 9.1.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 21.1.4, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Налайхын нүүрсний ордын далд уурхай (ам, цооног)-д нэгдсэн шалгалтыг явуулж, дүгнэлт гарган хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл



ахуйн шаардлага хангаагүй, аваар осол гарах, иргэдийн эрүүл мэнд, амь нас хохирох эрсдэлтэй болсон далд уурхайн талаар авах арга хэмжээний тухай саналыг шалгалтын дүнгийн хамт 2013 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт даалгасугай.

2. Налайхын нүүрсний ордын үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий нөөцийг тодруулан тогтоосны үндсэн дээр стандартад нийцсэн техник, технологи бүхий далд уурхайг байгуулах боломжийг судалж зохих журмын дагуу шийдвэрлэхийг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгасугай.

3. Налайхын нүүрсний ордод нүүрс олборлосны улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийлгэх асуудлыг зохих журмын дагуу зохион байгуулан энэ талаар шат дараалсан арга хэмжээ авахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт даалгасугай.

4. Налайх дүүрэгт хувиараа нүүрс олборлож байсан, ажилгүй болж байгаа иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулж, ажлын байраар хангах талаар холбогдох арга хэмжээ авахыг Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Налайхын нүүрсийг хувиараа ашиглаж байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай” Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 89 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

УУЛ УУРХАЙН САЙД

Д.ГАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 2 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

**Тооны дээд хязгаар, мөнгөн
төлбөрийн хэмжээ тогтоох тухай**

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5, 8 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:



1. 2013 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.

2. Цэргийн дүйцүүлэх албыг 2013 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 3.726.786 (гурван сая долоон зуун хорин зургаан мянга долоон зуун наян зургаан) төгрөг байхаар тогтоосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Сангийн сайд Ч.Улаан нарт, цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Д.БАТ-ЭРДЭНЭ

Засгийн газрын 2013 оны 47 дугаар
тогтоолын хавсралт

**2013 ОНД ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААХ
ИРГЭДИЙН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР**

№	Аймаг, нийслэл	Тооны дээд хязгаар
1	Архангай	40
2	Баян-Өлгий	20
3	Баянхонгор	20
4	Булган	35
5	Говь-Алтай	40
6	Говьсүмбэр	5
7	Дархан-Уул	40
8	Дорноговь	10
9	Дорнод	30
10	Дундговь	20
11	Завхан	30
12	Орхон	15
13	Өвөрхангай	30
14	Өмнөговь	40
15	Төв	40
16	Увс	35
17	Сүхбаатар	25
18	Сэлэнгэ	30
19	Ховд	40
20	Хөвсгөл	40
21	Хэнтий	20
22	Улаанбаатар	54
	БҮГД	659

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turin_medecelel@parliament.mn
Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.25

Индекс: 14003